

АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Хууль, эрх зүйн үндэслэл

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон.

Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.9-д “Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн **20.1-д** заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна” гэж заасан байна.

Ямар төрлийн үйл ажиллагаа хамаарагдах талаар заасан хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2-д “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах” гэж заасан.

Хуулийн 22.9.2-т заасан “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ”-гэдэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон асрамжийн үйлчилгээнээс гадна ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдэд зориулсан амрах, асруулах, сувилуулах, болон нийгэмшихэд чиглэгдсэн ашгийн төлөө бус байгууллагаас үзүүлж буй бусад бүх төрлийн төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээ, тус үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан барилга, бүтээн байгуулалтад оруулсан хөрөнгө оруулалтыг хамааруулна гэсэн тодорхойлсон.

Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.11-д “Энэ хуулийн 22.9-д заасны дагуу хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хяналт тавина” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтын дагуу Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө хэрэгжих бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны шаардлага, стандартыг шинээр боловсруулах шаардлагатай болж байна.

Хоёр. Нөхцөл байдал

Үндэсний статистикийн хорооны 2023 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад нийт 385.3 мянган ахмад настан, 111.2 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн, 1.3 сая хүүхэд байна.

Засгийн газраас дээрх иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

зэрэг бодлогын баримт бичгүүдэд холбогдох зорилт, үйл ажиллагааг тусган хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулвал аж ахуйн нэгж, байгууллагыг 1 хүртэлх хувиар татварын хөнгөлөлт эдлүүлэх хуулийн заалт шинээр баталсан.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эх, хүүхдийн саадгүй нэвтэрч, үйлчилгээ авах боломжтой холбогдох стандартад нийцсэн барилга байгууламж, зам, нийтийн тээвэр, гарц, орц, зогсоол, мэдээллийн хүртээмж хангалтгүй мөн стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэнгийн хэрэгцээ шаардлага байна.

Гурав. Зорилго

Монгол Улсын хүүхдийн тоглоом, зуслан, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламж, зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх.

Дөрөв. Гүйцэтгэх ажлын чиглэл

Татварын хөнгөлөлтөд хамруулах үйл ажиллагааны чиглэл, шаардлагыг тодорхойлох.

Тав. Үр дүн

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд нийгмийн үйлчилгээнд эрх тэгш, саадгүй хамрагдах боломж бүрдэнэ. Аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд энэ төрлийн бүтээн байгуулалтуудыг гүйцэтгэж, татварын хөнгөлөлтөд хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

АЖЛЫН ХЭСЭГ